



МОН-ГЕО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021... оны 04.-р сарын 29. өдөр

Дугаар 0/.

Улаанбаатар хот

“Мон-гео” ХКомпанийн дүрмийн 6.7 дахь заалт , Хувь нийлүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хуралд оролцсон хувь эзэмшигчдийн санал нэгтэй баталсныг үндэслэн

ТОГТООХ НЬ:

Нэг. Компанийн 2020 оны санхүүгийн тайланг зөвшөөрөхөөр тогтоосугай.

Хоёр. Компанийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч зөвшөөрсүгэй.

Гурав. Аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Дөрөв. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхтэй оролцох нөхцлийг бүрдүүлсүгэй.

Тав. Харьяа дээд байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийн хүрээнд компанийн дүрмээр тогтоосон зүйл заалтыг үндэслэн компанийн бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр тогтоосугай.

Зургаа. Хамтран ажиллах хүсэлт гаргасан компанийн үйл ажиллагааг харилцан дэмжиж хамтран ажиллах гэрээ байгуулахыг зөвшөөрөхөөр тогтоосугай.

Долоо. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ажлын байр нэмэгдүүлэх , цаашид бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгооор тогтоосугай.

Найм . Компанийн эзэмшлийн СХД болон ХУД -дэхь газрыг зөв зохистой ашиглах зорилгоор хийгдэх ажлуудын бизнес төлөвлөгөөг боловсруулах, холбогдох тооцоо судалгааг гаргаж шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг хуралдуулж шийдвэрлэсүгэй.

Ес . Тус компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлал бүхий 8,08 га газрын зориулалтыг өөрчлөх, үйл ажиллагааны болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор түрээслэх, худалдан борлуулах , үндсэн хөрөнгөөс хасах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр тогтоосугай.

Арав. Компанийн гүйцэтгэх захирлыг улируулан ажиллуулсугай.

Хурлын дарга / Н.Соёмбо /

Нарийн бичгийн дарга / Х.Анар /

